

**МОНГОЛ ХЭЛНИЙ ТАЙЛБАР ТОЛЬД ҮГИЙН УТГЫГ
ТАЙЛБАРЛАХ ОНОЛ-АРГА ЗҮЙН АСУУДАЛД**

Ж. Сэржээ *

Аливаа хэлний толь бичиг нь өөр хоорондоо ялгаа бүхий олон төрөл зүйл байх ба толь зүйн судлалд ерөнхийд нь хэл шинжлэлийн толь, нэвтэрхий толь хэмээн хоёр хуваан үздэг билээ. Энэхүү хоёр төрлийн толь бичигт хоёуланд нь тухайн хэлний үг үндсэн нэгж нь болох боловч нэвтэрхий толь бичигт тухайн үгээр илэрч буй юм, үзэгдэл, үйл явцын цаад мөн чанар буюу ухагдахууныг оновчтой, товч тайлбарлах нь гол зорилго байдаг бол хэл шинжлэлийн толь бичигт тухайн хэлнийхээ үгийг хүмүүсийн харилцааны хэрэглүүр, хэлний нэгж болох талаас нь түлхүү анхааран тайлбарласан байдаг. Энд л дээрх хоёр төрлийн толийн гол ялгаа оршдог.

Сүүлийн зуу гаруй жилд монгол хэлний үгийн сангийн судалгаа, түүний дотор монгол хэлний толь бичгийн салбар ихээхэн амжилт олж, олон арван нэр төрлийн толь бичгүүд хэвлэгдэн гараад байна. Цаашид ч олон толь гарах нь дамжиггүй. Харин энэ олон нэр төрлийн толиудын талаар нарийвчлан судалж, олсон ололт амжилт, гаргасан алдаа дутагдлыг нь шүүн хэлэлцсэн судлал, шүүмжийн бүтээл “Монгол хэлний үгийн сангийн судлал”-ын талаар хэвлэгдсэн нэгэн сэдэвт бүтээлүүдэд орсон “Монгол хэлний толь судлал”-ын тойм өгүүллүүдээс өөр бараг байхгүй байна. Монгол толь бичгүүдийг нарийвчлан судалж үзвэл олсон ололт амжилт ч бий, алдсан алдаа дутагдал ч бий. Энэ тухай профессор Ц.Шагдарсүрэн “1990-ээд оноос хойш ... янз бүрийн олон толь гарсан нь сайн хэрэг боловч хэл шинжлэл, толь зүйн үүднээс авч үзвэл цөмөөрөө биш юм аа гэхэд ихэнх нь зохих шаардлагыг хангаж чадаагүй, зарим нь гарын үзүүрээр хэтэрхий хялбарчилсан байдал харагдах бөгөөд энэ нь зохиогчийн хэл шинжлэл-толь зүйн онолын мэдлэг дутуугаас үүдсэн хэрэг буй заа. Тользүй гэдэг бол хэлшинжлэлийн нэг томоохон бие даасан салбар ухаан. Толь бичиг гэдэг бол эхлээд толь зүйн үүднээс арга зүйгээ зөв боловсруулах, өргөн мэдлэг, цаг хугацаа, тэсвэр тэвчээр шаарддаг зовлонтой ажил бөгөөд тэр хэрээрээ ганц сэдэвт хийгээд зэрэг горилох зохиол бичихтэй огт адилгүй болох нь олон түмэн хэрэглэгчээ тухайн хэлний зөв тогтолцооны зүгт заан хөтлөх үүрэгтэй байдагт оршино. Тийм ч учраас ац нийлээгүй маргаантай, хэл шинжлэлийн үүднээс буруу зөрүү зүйлийг толь бичигт оруулах ёсгүй.”/Ц.Шагдарсүрэн. 2009, 174-175-р тал/ гэж бичсэн байна.

* МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Монгол хэлний тэнхим

Миний бие энэ удаа монгол хэлний тайлбар толиудад үгийн утгыг хэрхэн тайлбарлаж байгаа, тэдний алдаа хийгээд ололттой талыг нь монгол хүн бүрийн сайн мэдэх таван хошуу малын тухайт үг болон, байгалийн “УС” болоод түүнээс үүсэлтэй хур тундасны зүйлд холбогдох үгийг хэрхэн тайлбарлаж байгаа баримтыг түшиглэн өгүүлэхийг зорьсон юм. Энэ хоёр бүлэг үгийн эхнийх нь буюу малын тухайт үгс нь нүүдэлчин монголчуудын аж амьдралын өвөрмөц хэвшил, зан заншилтай нарийн холбоотой учир бусад хэлэнд байдаг ойлголтоос зарим талаараа ялгаатай, өөрийн үндэсний онцлог бүхий утга илэрхийлдэг гэж хэлж болох бол хоёрдугаарх бүлэг үгс буюу “УС”-тай холбоотой байгалийн юм үзэгдлүүд дэлхий нийтэд түгээмэл учир тэдгээр ойлголтыг илэрхийлдэг үгсийн утга бараг бүх хэлэнд ялгаагүй нийтлэг байдаг. Өөрөөр хэлбэл УС-ыг мэдэхгүй, хэрэглэдэггүй хүн дэлхийд байхгүй, түүнийг илэрхийлэх үггүй хэл ч бас дэлхийд байхгүй түгээмэл зүйл юм. Ийм учраас энэ хоёр үг болон эдгээртэй утгын хувьд шууд холбогдох бүлэг үгсийн тухай өгүүлэхийг зорьсон юм.

Нэг. Малын тухайт үгсийг тайлбарлах нь

Монгол хүн бүрийн сайн мэдэх адуу, үхэр, тэмээ хонь, ямаа гэдэг таван хошуу малын нэрийг монгол хэлний тайлбар толиудад янз бүрээр тайлбарласан байна. Бүр тайлбарлах зарчмын хувьд ч нэлээд ялгаа байна. Жишээлбэл: **ҮХЭР** гэдэг үгийг **Товч тайлбар тольд**: “тугалмайт эвэрт, ац туурайт, хивэгчийн намын амьтан, эвэр гилгэр, сүүл урт”, **Дэлгэрэнгүй тайлбар тольд**: “Дэлэнтэн анги, туруутан баг, тугалмайтан овог, үхэр төрөл. Өвс идэшт хивэгч, том биет зэрлэг тэжээвэр олон зүйл адгуус”, **Монгол хэлний тольд**: “Бие бүдүүн, хүч их, хөлдөө туруутай, толгойдоо хос хөндий эвэртэй, сүүлийн үзүүртээ урт үстэй нэгэн зүйлийн хивэгч хөхтөн” гэж тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл орчин цагийн монгол хэлний гол гурван тайлбар толь бичигт биологи, амьтан судлалын талаас нь илүү анхаарч, хэтэрхий нэвтэрхий толийн шинжтэй тайлбар хийсэн учир ихэнх монгол хүн “үхэр” гэдэг малыг хэлээд байна гэж ойлгохгүйгээр болжээ. Тэгвэл **Шагжийн тайлбар тольд**: “Малын нэр. Хоёр эвэр буй. Дээдэд үүдэн шүд үгүй. Туурай хоёр хэлтэс. Эрийг тэрэг хөллөх, эмийг сүү саахын зэрэгт хэрэглэмүй.”, **Хорин наймт тайлбар тольд**: “Арван хоёр жилийн хоёрдугаарыг үхэр хэмээмүй. Ерд болбоос зургаан тэжээврийн нэгэн буюу олонх нь эвэртэй, амны дотор дээд шүдгүй, ац туурайтай бөгөөд анжис чирэх, тэрэг хөллөхийн гавьяа буй”, **Хорин нэгт тайлбар тольд**: “анжис чирэх, тэрэг хөллөхөд хэрэглэх малын нэр. Арван хоёр жилийн хоёрдугаарт буй. Толгойд эвэр буй. Амны дээд уурхайд шүдгүй, туурай нь хоёр хэлтэс.” хэмээн дорно дахины 12 жилийн он тоололтой холбон тайлбарласныг уншихад үхэр гэдэг нь ойлгогдож байгаа боловч бас төдий л оновчтой тайлбар болж чадаагүй ажээ. Тухайлбал таван хошуу малын дотроос монголчуудын сүү цагаан идээний хэрэгцээний ихэнхи /Монгол улсын сүүний үйлдвэрлэлийн 90%/-ийг үхэр хангадаг тул энэ үгийн тайлбарт “сүүг нь сааж хүнсэнд өргөн хэрэглэдэг” гэсэн тайлбар “анжис чирэх, тэрэг хөллөхөд хэрэглэх малын нэр” гэдгээс илүү чухал үүрэгтэй байх ёстой.

Монгол хэлний тайлбар толийн үгийн тайлбарыг уншаад монгол хэл мэддэг аливаа хүн ойлгож чаддаг, толгой үгийг нь харахгүй, зөвхөн тайлбарыг нь уншсан ч юуны тухай хэлж байгааг нүдээр харсан юм шиг тодорхой мэддэг байх ёстой. Өөрөөр хэлбэл, “Үхэр” гэдэг үгийг тайлбарласан дээрх толиудын эхний гурвынх нь тайлбараас бид **ямар нэгэн урт сүүлтэй, эвэртэй, бүдүүн амьтан** гэдгээс өөр тодорхой юм ойлгож

чадахгүйд хүрч байна. Ийм тайлбартай тайлбар толь байж болохгүй нь ойлгомжтой. Тэгвэл монгол хэлний тайлбар тольд үгийн үндсэн утгыг яаж тайлбарлах вэ? гэдэг асуудал урган гарч байна. Аливаа хэлний дэлгэрэнгүй тайлбар толь нь хоёр болон олон хэлний орчуулгын толь, сургалтын толиуд, идэвхитэй үгийн толь, үгийн язгуурын толь, өвөрмөц хэллэгийн толь, ойролцоо үгийн толь гэх мэтийн хэл шинжлэлийн олон зүйл толь бичгийг зохиох үндэс болдгоороо үгийн сангийн суурь судалгааны бүтээл гэж тооцогддог. Нэг үгээр хэлбэл, сайн тайлбар тольгүйгээр дээрх олон төрлийн толиудыг зохиох боломж хомс юм. Тийм учраас тайлбар толь зохиогчдын хариуцлага маш өндөр, үгийн утга, хэрэглээний талаар ихээхэн гүнзгий судалгаа хийсэн байх шаардлагатай бөгөөд үгийн утгыг хэн нэгэн зохиогч өөрийн санаагаар, тодорхой судалгаагүйгээр өнгөц тайлбарлаж болохгүй. Иймд тайлбар толийн тайлбарыг хэн нэгэн хүний бодол санаа биш, тухайн үеийн хэлний үгийн сангийн үндсэн утгын илэрхийлэл гэж үзэж болно.

Нүүдэлчин монголчуудын **МАЛ** гэдэг ойлголт бол бусад ард түмнийхээс, ялангуяа суурин амьдралтай ард иргэдийн гэрийн тэжээвэр амьтдаас эрс ялгаатай юм. Тухайлбал монголчууд нохой, гахай, тахиа, илжиг, луус зэрэг гэрийн тэжээвэр амьтдыг мал гэдэггүй. Тийм учраас монгол хэлний “Мал” гэдэг үгэнд хамаарч байгаа амьтад маань амьтны аймагт багтах бусад амьтнаас юугаараа ялгаатай юм бэ? гэдгийг эхлээд тодорхойлох нь чухал. Монголчуудын мал гэдэг бол хэдэн мянган жилийн тэртээгээс гаршуулан гэрийн болгосон өвсөн тэжээлт, сүүгээр бойжигч таван төрлийн амьтан юм. Тэдгээрийг монголчууд “таван хошуу мал” гэдэг. Нөгөө талаар хүний амьдралд зайлшгүй хэрэгтэй хоол унд, гэр орон, хувцас хунараа малаасаа гарган авах төдийгүй, тэднийг уналга, ачлага, тээврийн хэрэгсэл болгон ашигладаг. Малгүйгээр монгол хүний аж амьдрал, соёл, зан заншлыг төсөөлөх аргагүй учир амь зуулгынхаа үндэс болсон малаа “таван эрдэнэ” гэж бас нэрлэдэг.

Монголчуудын хувьд мал гэдэг бол эзэн хүний өгсөн бэлэн хоол тэжээлийг идчихээд хашаа хороондоо байж байдаг гэрийн тэжээвэр амьтан биш, жилийн дөрвөн улиралд уул хангай, тал хээр, говь нутагтаа чөлөөтэй бэлчин явж идэх өвс ургамлаа өөрсдөө сонгон олж иддэг, байгалийн цэвэр уснаас өөрийн дураар ундаалдаг, хонь ямаа, үхэр нь шөнөд хотондоо /гэрийнхээ гадаа/ ирж хонодог, адуу, тэмээ нь бэлчээртээ хээр хонодог амьтад билээ. Нөгөө талаар монгол мал өөрийн дайснаа таван мэдрэхүйгээрээ дамжуулан таньж, сэргийлэх байгалиас заяасан төрөлхийн сэргэлэн чадвартай байдаг. Өөрөөр хэлбэл ямар ч монгол мал харах, үнэрлэх эрхтэнээрээ чоныг таньж зугтах төрөлхийн мэдрэмжтэй байдаг. Монгол малын бэлчээрээр хооллож, чоноос сэргийлэх энэ чадвар нь бусад тэжээврүүдээс ялгарах гол ялгаа нь юм. Ийм учраас таван хошуу малын тус бүрийнх нь нэрийтгэл нэрийг тайлбарлахын тулд юуны өмнө **МАЛ** гэдэг үгээ оновчтой сайн тайлбарлах хэрэгтэй болно.

МАЛ гэдэг үгийг **Товч тайлбар тольд**: “Хөдөө аж ахуйн дөрвөн хөлт амьтан адгуус”, **Дэлгэрэнгүй тайлбар тольд**: “Гэрийн тэжээвэр адгуус, амьтан, хүн төрөлхтөний амин зуулга, аж ахуйн шаардлагаар удаан хугацаанд адуулан маллаж, ашиг шимийг нь хүртэж ирсэн таван хошуу мал”, **Шагжийн тайлбар тольд**: “Тэжээвэр адгуусан амьтны нэр. Мал тэжээвэр хэмээн холбон хэлэлцмүй”, **Хорин наймт тайлбар тольд**: “Хүний аливаа тэжээвэр бүхнийг мал хэмээмүй. Эртнээс манай монголын хөрөнгө болгон амьдарч бүхий адуу, тэмээ, үхэр, хонь, ямаа зэргийг таван хошуу мал хэмээмүй. Хүний гэрийн зургаан зүйл тэжээврийг мал адгуус хэмээмүй” /Морь, үхэр, хонь, гахай, нохой, тахиаг зургаан тэжээвэр хэмээмүй/, **Хорин нэгт тайлбар тольд**:

“морь, үхэр, хонь, ямаа, нохой, гахай зэргийнхийг нь цөм мал хэмээмүй”, **Монгол хэлний тольд:** “Хүн төрөлхтөний аж ахуйн шаардлага буюу бусад зорилгоор урт удаан хугацаанд сургаж тэжээсэн адгуусан амьтан. Тухайлбал таван хошуу мал, илжиг, луус зэрэг” гэх мэтээр тайлбарласан нь туйлын хангалтгүй байна.

Тэгвэл монгол хэлний тайлбар тольд **МАЛ** гэдэг үгийг яаж тайлбарлах вэ? Гадаад дотоодын олон толь бичгийн тайлбарыг нүүдэлч, малчин монголчуудын аж амьдрал, соёл, зан заншлын өвөрмөц орчинд оруулан авч үзвэл дараах байдлаар тайлбарлаж болмоор байна. Үүнд: *“Жилийн дөрвөн улиралд байгалийн бэлчээрээр маллан, мах, сүүгээр нь хоол хүнс бэлтгэж, арьс, үс ноосоор нь хувцас, орон сууцаа хийж, заримыг нь уналга, тээврийн хэрэгсэл болгон өдөр тутмынхаа амьдралд ашигладаг, нүүдэлчдийн амьдралын үндсэн эх сурвалж болсон өвсөн тэжээлт, гаршуулан өсгөдөг, таван төрлийн хөхтөн амьтан. Томыг нь бод мал, жижгийг нь бог мал хэмээн ялгадаг”* гэж тайлбарлаж болох юм. Нэгэнт **МАЛ** гэдэг үгээ оновчтой тайлбарлаж чадсан бол түүндээ түшиглэн таван хошуу мал тус бүрийн нэрийтгэл нэрийг тайлбарлахад хялбар болно. Тухайлбал:

АДУУ гэдэг үгийг **Товч тайлбар тольд:** “1. битүү туурайтны нэрийтгэл нэр, 2. Морь, гүү, азарга унагаар бүрэлдсэн сүрэг”, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “1. Дэлэнтний анги, туурайтны багийн адуунуудыг багтаасан төрлийн нэр, 2. Таван хошуу малын нэг, уналга ачлаганд хэрэглэнэ. 3. Морь, гүү, азарга, үрээ, байдас, унага даага тэргүүтнээс бүрэлдсэн сүрэг”, **Шагжийн тайлбар тольд:** “Морь үхрийн зэргийн сүргийг” **Хорин наймт тайлбар тольд:** “морь гүү сүрэглэсэн олныг адуу хэмээмүй”, **Хорин нэгт тайлбар тольд:** “морь үхрийн зэрэг малын сүргийг адуу хэмээмүй”, **Монгол хэлний тольд:** “толгой жижиг, хошуу урт, чих босоо, хүзүүндээ дэлтэй, сүүлэндээ урт хялгастай, дөрвөн мөч хүчирхэг бөгөөд мөч бүртээ битүү туурайтай, гүйхдээ сайн нэг зүйлийн хөхтөн. Унах хөллөхөд хэрэглэнэ” гэх мэтээр тайлбарласан байна. Тэгвэл адууны хамгийн гол шинжүүдийг нь ашиглан монгол хэлний тайлбар тольд: *“Монголчуудын таван хошуу малын нэгэн, бод мал, битүү туурайтай, өвсөн тэжээлт, хивдэггүй, хөхтөн амьтан. Уналгад хэрэглэхээс гадна мах, сүү, шир, хөөвөр хялгасыг нь ашиглана.”* хэмээн тайлбарлаж болмоор санагдана. Тэгвэл **Монголын нэвтэрхий тольд:** “Өвсөн тэжээлт, туурайтны төрөл. Хүн төрөлхтөн шинэ чулуун зэвсгийн сүүлч, хүрэл зэвсгийн эхэн үед адууг гаршуулжээ...” гэх мэтээр тайлбарласан байна.

ТЭМЭЭ гэдэг үгийг **Товч тайлбар тольд:** “нуруундаа нэг буюу хоёр бөхтэй, хивдэг том амьтан, бие өндөр болоод хүзүү гагагар”, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “Бие нь өндөр болоод хүзүү гагагар, нуруундаа нэг буюу хоёр бөхтэй, үс ноос сайтай, голдуу говьд байдаг, өл даах нь сайн, ихэвчлэн хүрэн улаан зүстэй, хивдэг бод мал.”, **Шагжийн тайлбар тольд:** “Ачихуйд хэрэглэх малын нэр. Бие өндөр хүзүү гагуйсан, нуруунд хоёр бөх буй”, **Хорин наймт тайлбар тольд:** “өндөр их бие нь маш чийрэг бөгөөд өлсөх ундаасахыг тэсвэрлэж чадах чанар онцгой, өргөн зузаан хоёр бөх нь туг ширээ бөгөөд үлэмж хүндийг үүрч чадах бие нь их. Алс хол, хуурай далай мэт газарт боловч ачаа барааг улируулан хүргэх онгоц адил. Ар монголын заан хэмээн алдаршсан бөгөөд адгуус мал боловч арван хоёр жилийн шинж төгөлдөр тэмээ хэмээмүй”, **Хорин нэгт тайлбар тольд:** “юм хум ачихад хэрэглэх малын нэр. Бие өндөр, хүзүү гагайсан, нуруунд хоёр бөх буй”, **Монгол хэлний тольд:** “бие өндөр том, нуруундаа бөхтэй, таваг нь хавтгай бөгөөд махлаг ултай болохоор элс манхаар явахад тохиромжтой. Давхар аньсагатай, элс шуургаас айхгүй, хивж чаддаг, өлсөх цангахыг сайн даадаг

хөхтөн. Үнэрлэх сэрэл сайн тул алсаас усны сурвалж ба салхи шуурга болохыг мэддэг. Уналга хөллөгөөнд хэрэглэнэ. Элс манхан газрын чухал хөлбөрийн мал мөн.” гэх мэтээр тайлбарласан байна.

Тэгвэл таван хошуу мал дотроо ялгарах тэмээний гол шинжүүдэд нь тулгуурлан, монгол хэлний тайлбар тольд: *“Монголчуудын таван хошуу малын нэгэн, бод мал. Өндөр том биетэй, гагагар хүзүүтэй, нуруундаа хоёр бөхтэй, хөлийн таваг нь хавтгай бөгөөд зөөлөн ултай, үс ноос ихтэй, говь газарт бэлчээрлэн нутаглахад тохиромжтой, хивдэг, хөхтөн амьтан. Мах, сүү, арьс шир, ноосыг нь ашиглана. Бас ачлага, уналга, хөллөгөөнд хэрэглэнэ”* гэж тайлбарлах боломжтой юм. Тэгвэл **Монголын нэвтэрхий тольд**: “Тэмээний овгийн төрөл. Жин 800 кг. Наран тэмээ /ганц бөхтэй/, хоёр бөхт тэмээ гэсэн хоёр зүйл бий. Монголын уугуул амьтан хавтгай хэмээх тэмээн гөрөөс говь нутагт бий. Тэмээ дээд эрүүндээ хос соёо, хос үүдэн шүдтэй. Цөсний уутгүй, цусны улаан цогцос нь зууван хэлбэртэй. Өөхнөөс тогтсон бөхтэй, 30-35 насалдаг...” гэх мэтээр тайлбарласан байна.

ҮХЭР гэдэг үгийг **Товч тайлбар тольд**: “тугалмайт эвэрт, ац туурайт, хивэгчийн намын амьтан, эвэр гилгэр, сүүл урт”, **Дэлгэрэнгүй тайлбар тольд**: “Дэлэнтэн анги, туруутан баг, тугалмайтан овог, үхэр төрөл. Өвс идэшт хивэгч, том биет зэрлэг тэжээвэр олон зүйл адгуус”, **Шагжийн тайлбар тольд**: “Малын нэр. Хоёр эвэр буй. Дээдэд үүдэн шүд үгүй. Туурай хоёр хэлтэс. Эрийг тэрэг хөллөх, эмийг сүү саахын зэрэгт хэрэглэмүй.”, **Хорин наймт тайлбар тольд**: “Арван хоёр жилийн хоёрдугаарыг үхэр хэмээмүй. Ерд болбоос зургаан тэжээврийн нэгэн буюу олонх нь эвэртэй, амны дотор дээд шүдгүй, ац туурайтай бөгөөд анжис чирэх, тэрэг хөллөхийн гавьяа буй”, **Хорин нэгт тайлбар тольд**: “анжис чирэх, тэрэг хөллөхөд хэрэглэх малын нэр. Арван хоёр жилийн хоёрдугаарт буй. Толгойд эвэр буй. Амны дээд уурхайд шүдгүй, туурай нь хоёр хэлтэс.”, **Монгол хэлний тольд**: “Бие бүдүүн, хүч их, хөлдөө туруутай, толгойдоо хос хөндий эвэртэй, сүүлийн үзүүртээ урт үстэй нэгэн зүйлийн хивэгч хөхтөн. Хөллөгөөний мал болгон хэрэглэхээс гадна мах сүүг нь идэж, арьс үс ясыг ашиглаж болно. Манай улсад монгол үхэр, усан үхэр, сарлаг зэрэг хэдэн зүйл буй” гэх мэтээр нэвтэрхий толийн тайлбар маягтай тайлбарласаар ирсэн байна.

Бидний бодлоор энэ үгийг монгол хэлний тайлбар тольд: *“Монголчуудын таван хошуу малын нэгэн, бод мал. Салаа туурайтай, дээд үүдэн шүд үгүй, хивдэг, эвэртэй ба эвэргүй ч байдаг, хөхтөн амьтан. Монголчуудын сүү, махны хэрэгцээний ихэнхийг хангадаг. Арьс шир, хялгас хөөврийг нь ашиглана. Шарыг тэргэнд хөллөж тээврийн хэрэгсэл болгохоос гадна унаа болгон хэрэглэнэ.* гэж тайлбарлах боломжтой гэж үзэж байна. Тэгвэл энэ үгийг **Монголын нэвтэрхий тольд**: “Сээр нуруутны хүрээ, хөндий эвэртний язгуур, хөхтөний анги, салаа туурайтны баг, цөгцөн шүдтэн буюу хивэгчдийн дэд баг, үхрийн зүйлд хамаарах мал...” гэх мэтээр тайлбарлажээ.

ХОНЬ гэдэг үгийг **Товч тайлбар тольд**: “гэрийн тэжээвэр, сүүн тэжээлт хивдэг адгуус, Монголын таван хошуу малын нэг, төрөлх номхон, сүү ба мах нь сайн, үс буржгар зөөлөн, ноос нь арвин, эсгий болоод нэхмэл хийхэд маш зохимжтой”, **Дэлгэрэнгүй тайлбар тольд**: “Таван хошуу малын нэг, гэрийн тэжээвэр, сүүн тэжээлт хивдэг мал, төрөлх номхон, сүү ба мах нь сайн, үс буржгар зөөлөн, ноос нь арвин, эсгий болоод нэхмэл хийхэд маш зохимжтой”, **Шагжийн тайлбар тольд**: “Тэжээврийн нэг. Төрөлх номхон, үс бужигархан, туурай хоёр хэлтэс, сүүл их. Сүүл бага нь бас буй. Бас хүний хумсан дор гарсан цагаан дуслыг нь”, **Хорин наймт тайлбар тольд**: “мал тэжээврийн нэр. Толгойд эвэртэй, эвэргүй цөм буй. Туурай хоёр хэлтэс, сүүл их бөгөөд

хавтгай, үс буржгар. Арван хоёр жилийн наймдугаарт буй”, **Хорин нэгт тайлбар тольд**: “тэжээврийн нэр. Арван хоёр жилийн наймдугаарт буй. Толгойд эвэр буй, туурай хоёр хэлтэс, сүүл их. Сүүл бяцхан нь хятад хонь мөн. Үс бужгир.” **Монгол хэлний тольд**: “хөхтөн, хивэгч амьтан. Таван хошуу малын нэг, хошуу нь монхор урт, дөрвөн мөч нь охор, ноос нь урт бөгөөд бужгир зөөлөн. Олонх нь цагаан зүсэмтэй, сүүл нь бүдүүн тарган бөгөөд унжгар, төрөл зүйл олон, мах нь идшинд орно. Ноосоор нь бараа нэхэж арьсаар нь хувцас ба элдэв эдлэл хийдэг” гэх мэтээр тайлбарласаар иржээ. Зарим тайлбарт сүүн тэжээлт амьтан гэсэн нь шинжлэх ухааны хувьд буруу юм. Сүүгээр бойжигч амьтан байхаас бус сүүн тэжээлт амьтан байхгүй.

Хонь гэдэг үгийг монгол хэлний тайлбар тольд: *“Монголчуудын таван хошуу малын нэгэн, бог мал. Ихэнх нь цагаан зүстэй, хавтгай том өөхөн сүүлтэй. Салаа туурайтай, дээд үүдэн шүд үгүй, хивдэг, эвэртэй ба эвэргүй ч байдаг хөхтөн амьтан. Нүүдэлчид ноосоор нь эсгий хийж гэрээ бүрэхээс гадна арьсаар нь хүйтний улирлын дээл хувцас хийдэг. Мах сүүгээр нь хоол цай хийдэг.”* хэмээн тайлбарлаж болно. Тэгвэл **Монголын нэвтэрхий тольд**: “Хос туурайт хивэгч, гэрийн тэжээвэр адгуус, монголын таван хошуу малын нэг... Хонийг мах, ноос, сүү, арьс нэхийн чиглэлээр үржүүлдэг. Ноосны чанарыг харгалзан нарийн, нарийвтар, бүдүүн, бүдүүвтэр ноост хонь гэж ялгана...” гэх мэтээр тайлбарласан байна.

ЯМАА гэдэг үгийг **Товч тайлбар тольд**: “үс урт, сүүл бага, ац туурайтай, хивэгч хөхөөр өсөх амьтан, зэрлэг тэжээвэр хоёр зүйл бий”, **Дэлгэрэнгүй тайлбар тольд**: “Үс урт, сүүл годгор, хос туруутай, хивэгч дэлэнт амьтан. Зэрлэг тэжээвэр хоёр янз, олон зүйл бий”, **Шагжийн тайлбар тольд**: “Тэжээврийн нэр. Хонины нам, үс урт, сүүл бяцхан, баахан сэргэлэн”, **Хорин наймт тайлбар тольд**: хонины нам, үс урт, сүүл бяцхан, олонх нь толгойдоо эвэртэй”, “хонины нам, үс урт, сүүл бяцхан”, **Монгол хэлний тольд**: “хөхтөн, хивэгч амьтан. Өвсөн тэжээлт гэрийн тэжээвэр, эвэр нь гурвалжин бөгөөд матгар, үс нь урт бөгөөд шулуун, сүүл годгор, дөрвөн мөч хүчирхэг болохоор үсэрч харайхдаа сайн, эрүү дороо сахалтай, хар цагаан хөх загал зэрэг зүсэм буй. Мах сүүг нь идэж болно, арьс ноолуураар нь хувцас эдлэл хийж болно” гэх мэтээр тайлбарласан байна. Зарим тайлбарт зэрлэг тэжээвэр хоёр зүйл буй гэсэн нь чухал шаардлагатай биш юм. Учир нь монголд зэрлэг адуу, зэрлэг тэмээ, зэрлэг хонь бас бий. Тэднээс ганц ямааг онцлох шаардлагагүй. Харин тахь, аргаль угалз, хавтгай, янгир зэрэг үгийг тухай тухайд нь толгой үг болгон тольд оруулдаг.

Ямааг монгол хэлний тайлбар тольд: *“Монголчуудын таван хошуу малын нэгэн, бог мал. Урт үстэй, өтгөн ноолууртай, годгор жижиг сүүлтэй, эрүү дороо сахалтай. Салаа туурайтай, дээд үүдэн шүд үгүй, хивдэг, олонх нь эвэртэй байдаг хөхтөн амьтан. Хад асга бүхий газар явахдаа сайн, хөх том, сүү их, хоньтой хамт нэгэн сүрэг болгон малладаг”* хэмээн тайлбарлаж болох юм. Тэгвэл **Монголын нэвтэрхий тольд**: “Хөндий эвэртний язгуур, хонины дэд язгуур. Салаа туурайт хивэгч мал. Монголын таван хошуу малын нэг. Ямаанаас сүү, мах, ноос, ноолуур, арьс зэрэг бүтээгдэхүүнийг авна...” гэх мэтээр тайлбарлажээ.

Ер нь ямар нэгэн юмын бусдаас ялгарах гол ялгааг нь олж чадвал түүнийг нь ашиглан цөөн үгээр маш товчхон тайлбарлаж болно. Тухайлбал, бидний энд ярьж байгаа Адууг “хивдэггүй бод мал”, Үхрийг “дээд үүдэн шүдгүй бод мал”, Тэмээг “бөхтэй бод мал” гэх буюу Ямааг “сахалтай бог мал”, Хонийг “өөхөн сүүлтэй бог мал” гэх мэтээр тайлбарлахад монгол хүн ойлгоход түвэгтэй биш. Ийнхүү Мал, Адуу, Үхэр,

Тэмээ, Хонь, Ямаа гэсэн үндсэн үгсээ сайн тайлбарлаж чадсан бол Бод мал, Бог мал, Эх мал, Эцэг мал, Төл мал, Азарга, Гүү, Морь, Унага, Даага, Үрээ, Байдас, Бух, Буур, Хуц, Ухна, Үнээ, Ингэ, Тугал, Ботго, Хурга, Ишиг, Шар, Ат, Ирэг, Сэрх, Соёолон, Хязаалан, Шүдлэн, Гуна, Гунж, Дөнө, Дөнж, Тайлаг, Тором, Төлөг, Борлон, Малчин, Саальчин, Оторчин, Тууварчин, Адуучин, Хоньчин, Үхэрчин, Тэмээчин, Бэлчээр, Өвөлжөөн, Хаваржаан, Намаржаан, Зуслан, Отор, Хадлан, Саах, Саахалт, Төллөх гэх мэтийн мал аж ахуйн холбогдол бүхий бусад олон үгийг товч тодорхой, хэнд ч ойлгомжтойгоор тайлбарлах боломж бүрдэнэ.

Эдгээр тайлбар бол дээрх үгсийн үндсэн утгын тайлбар бөгөөд ойролцоо утга, эсрэг утга, холбоо үг, хоршоо үгийн нь утгаар нэмэн дэлгэрүүлэх шаардлагатай байдаг. Монгол хэлний тайлбар толиудад үгийн аймаг, нэр үгийн ганц олон тоо, тийн ялгал, үйл үгийн хэв байдал зэрэг хэл зүйн холбогдолтой, үгийн хувирлын талаарх тайлбаруудыг хийдэггүй учир бусад хэлний тайлбар толиудыг бодвол нэвтэрхий толийн шинж нь илүү давамгайлж байдаг онцлогтой юм.

Эцэст нь, монголчуудын таван хошуу мал гэдэг ойлголт суурин амьдралтай бусад ард түмнийхээс хэрхэн ялгаатай болохыг Зөвлөлт Холбоот Улсын /хуучин нэрээр/ Шинжлэх ухааны академийн Орос хэлний хүрээлэнгээс 1981 онд хэвлүүлсэн Орос хэлний дөрвөн боть тайлбар толийн жишээгээр харьцуулан үзье. Уг тольд мал гэдэг үгийг “Скот -четвероногие домашние сельскохозяйственные животные. Крупный рогатый скот, молочный скот, рабочий скот, падеж скота, убой скота.” хэмээн тайлбарлажээ. Мөн тэнд таван хошуу малыг “Лошадь - крупное домашнее животное, используемое для перевозки людей, грузов и т.п., Корова - крупное домашнее молочное животное, самка быка., Верблюды - крупное одногорбое или двугорбое жвачное животное, отличающееся большой выносливостью и обитающее в пустынях и сухих степях., Коза - домашнее рогатое жвачное сем. полорогих, дающее молоко, шерсть, мясо. Самка козла. Овца - небольшое домашнее жвачное животное сем. полорогих, дающее молоко, шерсть, мясо. Самка барана.” гэж тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл, мал гэдэг үгийг дөрвөн хэлтэй, гэрийн, хөдөө аж ахуйн амьтан, адууг хүн болон ачаа зөөхөд ашигладаг гэрийн том амьтан, үхрийг гэрийн том сүүтэй амьтан, тэмээг говь цөл, хуурай тал газар оридог, ихээхэн тэсвэртэй нэг юмуу хоёр бөхтэй амьтан, хонийг ноос, мах, сүү өгдөг, тугалмайтны овгийн том биш хивэгч амьтан. Хуц, эмийг нь хонь гэдэг., ямааг сүү, ноос, мах, өгдөг, тугалмайтны овгийн гэрийн хивэгч амьтан. Ухна, эм нь.” гэх мэтчилэн тайлбарласан байна. Эдгээр үгийг монгол хэлний тайлбар тольд ингэж тайлбарлаж болохгүй нь тодорхой. Тэгвэл хаана ч байдаг, ямар ч хэлэнд адилхан ухагдахуун илэрхийлдэг хүн, хувцас, хоол, унд, ширээ, сандал, бичиг, цэцэг, мод, газар, шороо, тэнгэр, гол мөрөн, нуур, шувуу, ус, агаар гэх мэтийн маш олон үгийг олонх хэлэнд бараг адилхан тайлбарлана. Энэ тухай “Ус болон түүнээс үүсэх байгалийн үзэгдлүүдийн нэрийг тайлбарлах нь” нэртэйгээр үргэлжлэл дараагийн дугаарт.

НОМ ЗҮЙ

1. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Таван боть, Ерөнхий редактор Л.Болд, УБ. 2008 он /Дэлгэрэнгүй тайлбар толь/
2. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966 он /Товч тайлбар толь/

3. Монгол хэлний толь. Эрхлэн найруулагч Ц.Норжин, Ман.Мөрөн. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1999 он /Монгол хэлний толь/
4. Монгол үгний тайлбар толь. Шагж найруулан зохиов. Монгол улсын Соёлын сан, Дундад улсын үндэстний хэвлэлийн хороо. 1998 он. / Шагжийн тайлбар толь/
5. Хорин нэгт тайлбар толь. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1979 он / Хорин нэгт тайлбар толь/
6. Хорин наймт тайлбар толь. Намжилмаа эмхлэв. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1994 он / Хорин наймт тайлбар толь/
7. Монгол хэлний үгийн сан судлал “Монгол улсын шинжлэх ухаан” цувралын 12 дугаар боть УБ. 2009 он. 126-р тал
8. Монголын нэвтэрхий толь I, II боть, УБ. 2000 он
9. Словарь русского языка, в четырех томах, Москва. 1981

SUMMARY

This paper discusses the differences of the notion on five types of animals/livestock between Mongolians and the settled people using four-volume Russian thesaurus dictionaries compiled by the Russian Institute, Academy of Sciences, USSR in 1981. In this dictionary, the words related to livestock have been explained as follows: *'cattle'* - four legged, domestic and farm animals; *'horse'* - a large domestic animal that is used for transportation of people, goods; *'cow'* - a large domestic dairy animal; *'camel'* - one or two humped large animal with great stamina in deserts and Gobi; *'sheep'* - not big, domestic ruminant animal giving milk, wool and meat; the female sheep/ram *'goat'* - domestic ruminant animal giving milk, wool and meat; the female goat.

Obviously these words cannot be explained similarly in Mongolian dictionaries. While many generic words like person, clothes, food, drinks, table, chair, flower, tree, land, sky, river, lake, water, air, bird etc., can be explained in same way throughout every language due to identical meanings. More detailed explanations will be given in the next article 'Explanation of names of natural phenomena related with water'.